



**“УУЛ УУРХАЙ БА ЭДИЙН ЗАСАГ:
ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ШИЙДЭЛ”**



Уул уурхайн салбарт КОВИД-19-ийн үзүүлсэн нөлөө

Г. Рагчаасүрэн (ЭЗСЭШХ)

01/18/2022

Агуулга



1. Зорилго, арга зүй
2. Монгол Улсад КОВИД-19-ийн үзүүлсэн нөлөө
 - Эдийн засагт үзүүлэх нөлөө
 - Уул уурхайн салбарт үзүүлэх нөлөө
3. Компанийн түвшинд үзүүлэх нөлөө – Түүвэр судалгааны үр дүн
 - Үйлдвэрлэлд үзүүлэх нөлөө
 - Борлуулалтад үзүүлэх нөлөө
 - Санхүүжилтэд үзүүлэх нөлөө
 - Компанийн хариу үйлдэл
 - Засгийн газрын арга хэмжээний талаарх сэтгэгдэл
4. Богино хугацааны макро эдийн засгийн төлөв байдал ба уул уурхайн салбарын сэргэлтийн хувилбарууд
5. Дүгнэлт

Зорилго, арга зүй



Үндсэн зорилго: КОВИД-19-ийн Монголын уул уурхайн салбарт үзүүлэх нөлөөллийг үнэлэх

Арга зүй:


1. Хоёрдогч мэдээллийн шинжилгээ
 - Монгол Улсын эдийн засаг, уул уурхайн салбарт КОВИД-19-ийн нөлөөллийн баримт бичиг, хоёрдогч мэдээллийн шинжилгээ
2. Анхдагч мэдээллийн шинжилгээ
 - Уул уурхайн компаниудаас авсан судалгаа
 - КОВИД-19-ийн уул уурхайн компаниудад үзүүлэх нөлөө, түүний шалтгаан, компаниудын ирээдүйн хүлээлтийг тодруулах
3. CGE загварчлал
 - Богино хугацааны макро эдийн засгийн төлөв байдал
 - Уул уурхайн салбарыг сэргэх өөр хувилбаруудын дагуу ойрын хугацааны эдийн засгийн үзүүлэлтүүдийг таамаглах

*Монгол Улсад КОВИД-19-ийн үзүүлсэн
нөлөө*

Өнөөгийн нөхцөл байдал



КОВИД-19-ийн бүртгэгдсэн тохиолдол, хөл хорио



ЗГ-ын авсан арга хэмжээ:

- Хилийн хаалт
- Сургууль хаах
- Аяллын хязгаарлалт
- Хөл хорио тогтоох

Вакцинжуулалт (2021 оны 6-р сарын байдлаар)

- 1.85 сая хүн (насанд хүрэгчдийн 85%) эхний тунгаар вакцин хийлгэсэн
- 1.45 сая хүн (насанд хүрэгчдийн 67%) хоёр дахь тунгаар вакцин хийлгэсэн

ЗГ-аас хэрэгжүүлсэн арга хэмжээ



Төсвийн бодлогын арга хэмжээ

- 2 багц арга хэмжээ – 2020 онд нийт 6 их наяд төгрөг (ДНБ-ий 16.2%)
 - 2020 оны 3-р сар – 5.1 их наяд төгрөгийн анхны багц арга хэмжээ
 - 2020 оны 5-р сар – Хоёр дахь багц арга хэмжээ – 0.9 их наяд төгрөг
- 2020 оны 12-р сар
 - 2021 оны 7-р сар хүртэл цахилгаан, дулааны төлбөрийн чөлөөлөлт
 - Эрдэнэт үйлдвэр – 650 тэрбум төгрөг
 - Сайжруулсан шахмал түлшний үнийг 75%-р бууруулсан
 - Эрдэнэс Тавантолгой – 69 тэрбум төгрөг
- 2021 оны 4-р сар
 - Иргэн бүрд 300 мянган төгрөг олгосон
 - Оюутолгойн татвараар санхүүжүүлсэн – 1 их наяд гаруй төгрөг

Мөнгөний бодлогын арга хэмжээ

- Монголбанк бодлогын хүүгээ 6% хүртэл бууруулсан
- Хэрэглээний зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг 12 сар, ипотекийн зээлийг 6 сараар хойшлуулах боломжтой
- ЗГ, Монголбанк 2021-2024 он хүртэл эдийн засгийг сэргээх 10 их наяд төгрөгийн дунд хугацааны төлөвлөгөөг хэрэгжүүлсэн

Уул уурхайн салбарыг дэмжих арга хэмжээ

- Хятадтай хилээ хааснаар худалдаа, тээвэрлэлт тасалдсан
- 2020 оны 8-р сар – “Ногоон гарц” журмыг хэрэгжүүлсэн
- Уул уурхайн салбарт чиглэсэн тусламжийн тодорхой арга хэмжээ байхгүй

Монголын эдийн засагт үзүүлэх нөлөө

ДНБ ба үйлдвэрлэл

- Бодит ДНБ 2020 онд 5.3%-иар буурсан (2010 оны үнээр 18 их наяд төгрөг)
- Нийлүүлэлтийн талаас, хөдөө аж ахуйгаас бусад бүх салбар уналтад орсон


ДНБ-ий бодит өсөлтөд салбарын хувь нэмэр, 2020

	ДНБ-ий бодит өсөлт, %	Салбарын хувь нэмэр
ДНБ-ий бодит өсөлт	-5.3	-5.3
Хөдөө аж ахуй	6.2	0.8
Үйлдвэрлэл	-1.1	-0.1
Уул уурхай	-9.4	-2.0
Үйлчилгээ	-7.1	-3.0
Бүтээгдэхүүний цэвэр татвар	-9.8	1.1

Төсөв

- Төсвийн алдагдал 4.54 их наяд төгрөг (ДНБ-ий 12.3%)
- Төсвийн орлого 13.6%-иар буурч, төсвийн зарлага 19.7%-иар өссөн
- Засгийн газрын нийт өр өмнөх оны мөн үеэс 15.3%-иар (өнөөгийн үнээр 27.9 их наяд төгрөг) өссөн


Улсын төсвийн үзүүлэлт, их наяд төгрөг



Монголын уул уурхайн салбарт үзүүлэх нөлөө



Ашигт малтмалын экспорт (алтнаас бусад), сая ам.доллар



Ашигт малтмалын экспортын өсөлтөд оруулсан хувь нэмэр, ашигт малтмалын төрлөөр, %


	2020.I	2020.II	2020.III	2020.IV	2021.I
Ашигт малтмалын экспорт (алтнаас бусад)	-40.1	-38.0	-3.5	15.8	100.5
Нүүрс	-26.5	-25.2	-6.6	0.6	49.6
Зэсийн баяжмал	-10.3	-9.2	4.0	16.7	30.5
Төмрийн хүдэр	2.3	-0.2	0.6	1.6	11.0
Бусад ашигт малтмал	-5.7	-3.3	-1.6	-3.1	9.4

- 2020 онд уул уурхайн салбарын бодит ДНБ өмнөх оны мөн үеэс 9.4%-иар буурсан (3.58 их наяд төгрөг)
- Ашигт малтмалын нийт экспорт (алтнаас бусад) өмнөх оны мөн үеэс 17.6%-аар буурсан
 - Гадаад шок:
 - Хятадын эрэлтийн хэлбэлзэл
 - ГШХО-ын урсгал буурсан
 - Дэлхийн үнийн шок
 - Дотоод шок:
 - Үйлдвэрлэлийн тасалдал
 - Тээврийн тасалдал
- Үнийн өсөлтөөс шалтгаалж алтны экспорт 3 дахин өссөн


Монголын уул уурхайн салбарт үзүүлэх нөлөө



Өдөрт ГС-ГМ боомтоор өдөрт нэвтэрсэн нүүрс ачсан машины дундаж тоо, хагас жилээр



Уул уурхайн салбарын ГШХО, сая ам.доллар



Нүүрс

- Нүүрсний экспортын хэмжээ 2020H1-д огцом буурч, 2020H2-д өмнөх оны мөн үеэс 8.2%-аар өссөн
- 2020 оны 8-р сар – БНХАУ-ын хилийн боомтоор нүүрсний экспортыг дэмжих зорилгоор “Ногоон гарц” журмыг хэрэгжүүлэв

Зэс, төмрийн хүдэр

- Зэс, төмрийн хүдрийн экспортын өөрчлөлтөд Хятадын эрэлт, зах зээлийн үнийн өөрчлөлт нөлөөлсөн.
- 2020 онд зэсийн үнэ 3-р сарын доод цэгээс (4617 ам.доллар/тонн) 73%-иар өсөж, оны эцэст 7964 ам.доллар/тонн хүрэв

Уул уурхайн салбарт ГШХО

- Уул уурхайн салбарт оруулсан ГШХО-ын жилийн нийт урсгал 1.68 тэрбум ам.доллар хүрж, өнгөрсөн оны мөн үеэс 29.3%-аар буурсан
- Энэ нь Оюутолгойн ил уурхайн хөрөнгө оруулалт 17.4%-аар (228 сая ам. доллар) буурсантай холбоотой

*Компанийн түвшинд үзүүлэх нөлөө
Судалгааны үр дүн*

Судалгааны тойм



- Гол зорилго: КОВИД-19-ийн уул уурхайн компаниудад үзүүлж буй нөлөөлөл, түүний шалтгаан нөхцөл, компаниудын богино хугацааны хүлээлтийг тодруулах
- ОУИТБС-аас гаргасан жагсаалтаас 2826 аж ахуйн нэгжтэй холбогдсон
- Үүнээс 252 уул уурхайн компаниас судалгаа авсан (санамсаргүй байдлаар сонгох боломжгүй байсан)
- Судалгааны хүрээ:
 - Үйлдвэрлэлд үзүүлэх нөлөө
 - Борлуулалтад үзүүлэх нөлөө
 - Санхүүжилт ба хөрөнгө оруулалт
 - КОВИД-19-ийн үед авч хэрэгжүүлсэн авсан арга хэмжээ
 - ЗГ-аас авсан арга хэмжээ, зохицуулалтын талаарх хандлага
 - Богино хугацааны хүлээлт


Судалгаанд хамрагдсан компаниуд, ашигт малтмалын төрлөөр

Ашигт малтмал	Давтамж	Хувь хэмжээ (%)
Алт	79	31.3
Нүүрс	45	17.9
Жонш	36	14.3
Хайрга, шороо	36	14.3
Төмрийн хүдэр	15	6.0
Зэс	6	2.4
Бусад ашигт малтмал	35	2.0
	252	100.0

Үйлдвэрлэлд үзүүлэх нөлөө

- Судалгаанд оролцсон уул уурхайн компаниудын 42% (106) нь 2020 онд үйлдвэрлэл бууруулсан гэж мэдээлсэн
- 17.1% (43) нь үйлдвэрлэлээ бүрэн зогсоосон
- 67% (169) нь 2020 оны төлөвлөгөөнөөсөө бага үйлдвэрлэсэн
- Үйлдвэрлэл буурсан компаниудын ихэнх хувийг жижиг компаниуд бүрдүүлсэн
- Гэсэн хэдий ч компаниуд өөдрөг байсан - 77% (69) нь үйлдвэрлэл дунджаар 8-9 сарын дотор сэргэнэ гэж таамагласан

Үйлдвэрлэлийн өөрчлөлт



2020 оны үйлдвэрлэлийн төлөвлөгөөний гүйцэтгэл




Үйлдвэрлэлийн бууралтын шалтгаан, n=106




Борлуулалтад үзүүлэх нөлөө

- Уул уурхайн компаниудын 69% (173) нь дотоодын зах зээлд бүтээгдэхүүнээ борлуулдаг
- Жижиг компаниуд дотоодын зах зээлд борлуулж, томоохон компаниуд экспортолдог
- Судалгаанд хамрагдсан уул уурхайн компаниудын 42% (107) нь 2020 онд борлуулалт буурсан гэж мэдээлсэн
- Уул уурхайн компаниудын 67% (168) нь 2020 оны төлөвлөгөөнөөсөө бага борлуулалт хийсэн
- Үйлдвэрлэлийн нэгэн адил компаниуд борлуулалт сэргэнэ гэсэн хүлээлттэй байна
 - 64% (68) борлуулалт сэргэнэ гэж тооцоолсон
 - Үүнд дунджаар 8 сарын хугацаа шаардагдана

Борлуулалтын өөрчлөлт



2020 оны борлуулалтын төлөвлөгөөний гүйцэтгэл



Борлуулалт бууралтын шалтгаан, n=107




Санхүүжилт ба хөрөнгө оруулалт




- Уул уурхайн компаниудын 78% (196) нь санхүүгийн бэрхшээлтэй тулгарсан гэж мэдэгдсэн
- Компаниудын 30.6% (78) нь хөрөнгө оруулалтаа бууруулсан эсвэл хойшлуулсан
 - Дотоодын хөрөнгө оруулалттай компаниуд төлөвлөсөн хөрөнгө оруулалтынхаа 69%-г авч чадсан бол гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд төлөвлөсөн хөрөнгө оруулалтынхаа 58%-г л авч чадсан.
- Уул уурхайн компаниуд ирээдүйн хөрөнгө оруулалтын талаар тодорхой хүлээлтгүй байсан
 - 47% (118) нь тодорхой хүлээлттэй байсангүй

Санхүүгийн бэрхшээл тулгарсан эсэх



КОВИД-19-тэй холбоотой тулгарсан санхүүгийн бэрхшээлүүд, n=107




Компаниудын авсан арга хэмжээ



- Судалгаанд хамрагдсан уул уурхайн компаниудын 47% (119) нь ямар нэгэн менежмент, хүний нөөцийн арга хэмжээ хэрэгжүүлсэн
 - Тухайлбал, Оюутолгой төслийн нийт ажиллах хүчнийхээ тоог 7100-аас 2960 болгон цөөрүүлсэн
- Үүнтэй адилаар 42% (106) нь санхүү, хөрөнгө оруулалтын дэмжих ямар нэгэн арга хэмжээ хэрэгжүүлсэн
- Гэсэн хэдий ч компаниудын 57% (143) нь КОВИД-19-тэй холбоотой тусламж, хандив өгсөн гэж мэдэгджээ
 - Дундаж хандив: 273.8 сая төгрөг
 - Хамгийн их хандив: 1 тэрбум төгрөг
 - ТӨҮГ илүү их хандив өгөх хандлагатай

Хэрэгжүүлсэн менежмент, хүний нөөцийн арга хэмжээ, n=119



Хэрэгжүүлсэн санхүү, хөрөнгө оруулалтыг дэмжих арга хэмжээ, n=106



Компаниудын авсан арга хэмжээ

- Судалгаанд хамрагдсан уул уурхайн компаниудын 14% (35) нь борлуулалтыг дэмжих арга хэмжээ хэрэгжүүлсэн байна

Хэрэгжүүлсэн борлуулалтын арга хэмжээ, n=35



- Үүнээс гадна компаниудын 46% (117) нь ЗГ-ын байгууллагын санхүүг дэмжих ямар нэгэн арга хэмжээнд хамрагдсан

Хамрагдсан ЗГ-ын арга хэмжээ, n=117



ЗГ-аас авсан арга хэмжээний талаарх хандлага



Судалгаанд хамрагдсан уул уурхайн компаниудын диилэнх нь ЗГ-ын хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг мөрдөхөд хүндрэлтэй байсан гэж мэдэгдсэн

ЗГ-ын арга хэмжээг мөрдөхөд хүндрэлтэй байсан эсэх

	Оноо	Давтамж	%
Хүндрэлгүй	0 to 4	89	35.3
Хүндрэлтэй	5 to 10	163	64.7
Нийт		252	100.0

ЗГ-ын арга хэмжээг дагаж мөрдөхөд гарсан хүндрэл, n=163



Олборлох ашигт малтмалын төрлөөрх ялгаа

Зэс

- Хөдөлмөр тасрахад сөргөөр нөлөөлсөн
- Ажилтны ээлжийн хуваарийг өөрчилсөн
- ГШХО-ын буурсан

Нүүрс

- Борлуулалтын хэмжээ буурсан (үнийн өөрчлөлтөөс илүү нөлөөлсөн)
- ЗГ-ын хэрэгжүүлсэн арга хэмжээ (хил хаах, аялалын хязгаарлалт) борлуулалтыг бууруулсан

Алт


- Үнийн өсөлтөөс үүдэн КОВИД-19-ийн нөлөө бага
- Гол худалдан авагч - Монголбанк
- Хөдөлмөрийн тасалдал
- Хил хааснаар алтыг хууль бусаар хил нэвтрүүлэхээс сэргийлсэн

Төмрийн хүдэр

- КОВИД-19-ийн нөхцөл байдал хамгийн их сөргөөр нөлөөлсөн
- Тээврийн саад бэрхшээл их
- Үйлчлүүлэгчээ алдсан
- Жижиг компаниуд үнийн өсөлтийг давуу талыг ашиглаж чадахгүй

*Богино хугацааны макро эдийн
засгийн төлөв байдал ба уул уурхайн
салбарын сэргэлтийн хувилбарууд*

Арга зүй – Динамик CGE загвар



- Загварын хэрэгсэл: ERI стандарт динамик ерөнхий тэнцвэрийн загвар (CGE)

- Нэг улсын – Рекурсив динамик загвар
- 33-ийн эрэлт, нийлүүлэлт нь ашгийг болон ханамжийг хамгийн их байлгах нөхцөлөөс гарна
- Вальрасын хууль: Бүх зах зээлийн тэнцвэр нэгэн зэрэг хангагдана
- Шугаман ба шугаман бус тэгшитгэлийн систем
- Олон сектортой (үйлдвэрлэгчтэй)
- Капитал, хөдөлмөр гэсэн хүчин зүйлстэй
- Агентууд: Өрх, ЗГ, Гадаад сектор
- Татварын элементүүдийг агуулдаг

Үндсэн мэдээллийн сан: 2020 оны Нийгмийн бүртгэлийн матриц (SAM)



- 63 багана, мөр бүхий квадрат матриц
 - 3 агент (Өрх, ЗГ, Гадаад сектор)
 - 2 үйлдвэрлэлийн хүчин зүйл (Хөдөлмөр, Капитал)
 - 19 салбар
 - 16 бүтээгдэхүүн
 - 3 татварын элемент (шууд бас шууд бус)
 - Хадгаламж-Хөрөнгө оруулалт

2020 Макро SAM

Макро SAM 2020 (ДНБ-ий %)

		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
1	Хөдөлмөр								2.4	45.4					47.8
2	Капитал								0.1	44.2					44.4
3	Өрх	47.3	32.1		13.1				2.5						95.1
4	Засгийн газар			3.4		12.5	2.0	8.0	1.8	0.4	0.0				28.0
5	Шууд татвар			12.5											12.5
6	Импортын тариф										2.0				2.0
7	Бүтээгдэхүүний татвар										8.0				8.0
8	Гадаад сектор	0.4	12.3	0.7	1.5						53.9				68.8
9	Салбар										178.1				178.1
10	Бүтээгдэхүүн			57.1	14.7				58.3	88.2	19.9	20.1	8.3	-4.5	261.9
11	Хувийн ХО			12.9					2.6						15.6
12	Улсын ХО			8.5	-1.3				1.1						8.3
13	Нөөцийн өөрчлөлт											-4.5			-4.5
14	Нийт	47.8	44.4	95.1	28.0	12.5	2.0	8.0	68.8	178.1	261.9	15.6	8.3	-4.5	

Уул уурхайн салбар 2020 Макро SAM



- Нийт нэмэгдсэн өртгийн 24%
 - Нийт хөдөлмөрийн нэмэгдсэн өртгийн 8.1%
 - Нийт хөрөнгийн нэмэгдсэн өртгийн 40%
- Капитал ихтэй - Салбарын нэмүү өртгийн 82.8% нь капитал, 17.2% нь хөдөлмөр
- Уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн 45.8%-г завсрын хэрэглээ эзэлдэг
- Экспортод чиглэгдсэн - Ашигт малтмалын бүтээгдэхүүний 89.7%-г экспортолдог
 - Нийт экспортын 61.2%-г эзэлдэг

23

Зорилго, арга зүй

Монгол Улсад КОВИД-19-ийн үзүүлсэн нөлөө

Компанийн түвшинд үзүүлсэн нөлөө - Судалгааны үр дүн

Богино хугацааны макро эдийн засгийн төлөв байдал

Дүгнэлт

Хувилбарууд



Суурь хувилбар – “Жигд сэргэлт”

Уул уурхайн салбар 2021, 2022 онд жигд өсөлттэй байна

- КОВИД-19-ийн дэгдэлтийг вакцинжуулалтаар хяналтанд барина
- Хятадын эрэлт хэрэгцээ өндөр хэвээр байна бөгөөд дэлхийн зах зээлийн үнэ өснө

Хувилбар 1 – “U” хэлбэртэй сэргэлт

Уул уурхайн салбарын үйлдвэрлэл 2020-2021 оны хооронд тогтмол байна

- 2021 онд КОВИД-19-ийн дэгдэлт нэмэгднэ
- 2022 онд уул уурхайн салбар эрчимтэй сэргэнэ

Хувилбар-2 – “Урвуу-U” хэлбэртэй сэргэлт


Уул уурхайн салбарын үйлдвэрлэл 2021 онд хурдацтай өсөх боловч 2022 онд удааширна

- 2021 онд уул уурхайн салбарын хүчтэй сэргэлт
- Хятадын эрэлт буурч, 2022 онд нүүрсний импортыг хориглоно


Хувилбарууд дахь ашигт малтмалын экспорт, үнэ



Ашигт малтмалын экспорт, их наяд төгрөг




Ашигт малтмалын үнийн индекс



Макро эдийн засгийн үр дүн – ДНБ



- “Жигд сэргэлт” хувилбар
 - ДНБ 2021 онд 8.2%-иар, 2022 онд 7.3%-аар өснө
- “U” хэлбэртэй сэргэлт хувилбар
 - КОВИД-19-ийн дэгдэлт, түүнтэй холбоотой урьдчилан сэргийлэх арга хэмжээний улмаас, уул уурхайн салбарын сэргэлтийг нэг жилээр хойшлуулсан
 - ДНБ 2021 онд 1.9%-аар (НХЗБ 2%-аар өссөний улмаас) 2022 онд 7.3%-аар өснө
- “Урвуу-U” хэлбэртэй сэргэлт хувилбар
 - 2021 онд Хятадын эдийн засаг хүчтэй сэргэсний дараа 2022 онд эрэлт буурна
 - ДНБ 2021 онд 8.2%-аар, 2022 онд 1.54%-аар өснө



Макро эдийн засгийн үр дүн – “Жигд сэргэлт” хувилбар



Макро эдийн засгийн үзүүлэлт, их наяд төгрөг (2020 оны үнээр)

	Он	Бодит ДНБ	Өрхийн бодит хэрэглээ	ЗГ-ын бодит хэрэглээ	Бодит хөрөнгө оруулалт	Бодит экспорт	Бодит импорт
Үнэ цэнэ (Зах зээлийн үнээр)	2020	37.13	21.19	5.44	8.87	21.63	20.00
	2021	40.17	23.27	5.56	10.13	24.61	23.40
	2022	43.11	25.82	5.67	11.46	26.66	26.50
Жилийн өсөлт, %	2021	8.19	9.82	2.21	14.21	13.78	17.00
	2022	7.32	10.96	1.98	13.13	8.33	13.25

Макро эдийн засгийн үр дүн – “U” хэлбэртэй сэргэлт



Макро эдийн засгийн үзүүлэлт, их наяд төгрөг (2020 оны үнээр)

	Он	Бодит ДНБ	Өрхийн бодит хэрэглээ	ЗГ-ын бодит хэрэглээ	Бодит хөрөнгө оруулалт	Бодит экспорт	Бодит импорт
Үнэ цэнэ (Зах зээлийн үнээр)	2020	37.13	21.19	5.44	8.87	21.63	20.00
	2021	37.86	21.56	5.64	8.85	21.84	20.03
	2022	41.21	23.77	5.79	10.21	25.01	23.57
Жилийн өсөлт, %	2021	1.97	1.75	3.68	-0.23	0.97	0.15
	2022	8.85	10.25	2.66	15.37	14.51	17.67

“Жигд сэргэлт” хувилбартай харьцуулахад өөрчлөлтийн хувь

	Бодит ДНБ	Өрхийн бодит хэрэглээ	ЗГ-ын бодит хэрэглээ	Бодит хөрөнгө оруулалт	Бодит экспорт	Бодит импорт
2021	-5.75	-7.35	1.44	-12.64	-11.26	-14.40
2022	-4.41	-7.94	2.12	-10.91	-6.19	-11.06

Макро эдийн засгийн үр дүн – “Урвуу-U” хэлбэртэй сэргэлт



Макроэдийн засгийн үзүүлэлт, их наяд төгрөг (2020 үнэ)

	Он	Бодит ДНБ	Өрхийн бодит хэрэглээ	ЗГ-ын бодит хэрэглээ	Бодит хөрөнгө оруулалт	Бодит экспорт	Бодит импорт
Үнэ цэнэ (Зах зээлийн үнээр)	2020	37.13	21.19	5.44	8.87	21.63	20.00
	2021	40.17	23.27	5.56	10.13	24.61	23.40
	2022	40.79	23.13	5.76	9.81	24.55	22.46
Жилийн өсөлт, %	2021	8.19	9.82	2.21	14.21	13.78	17.00
	2022	1.54	-0.60	3.60	-3.16	-0.24	-4.02

“Жигд сэргэлт” хувилбартай харьцуулахад өөрчлөлтийн хувь

	Бодит ДНБ	Өрхийн бодит хэрэглээ	ЗГ-ын бодит хэрэглээ	Бодит хөрөнгө оруулалт	Бодит экспорт	Бодит импорт
2021	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
2022	-5.38	-10.42	1.59	-14.40	-7.91	-15.25

Засгийн газрын төсвийн үзүүлэлт



Төсвийн алдагдал, их наяд төгрөг (2020 оны үнээр)

Он	Суурь - Жигд сэргэлт	Хув.1 - "У" хэлбэртэй сэргэлт	Суурь ба Хув.1-ийн ялгаа, %	Хув.2- "Урвуу-У" хэлбэртэй сэргэлт	Суурь ба Хув.2-ийн ялгаа, %
2020	3.56	3.56	-	3.56	-
2021	3.39	4.12	21.6	3.39	0.00
2022	3.24	3.91	20.7	4.17	28.6

Өрийн ДНБ-д эзлэх хувь, %

Он	Суурь - Жигд сэргэлт	Хув.1 - "У" хэлбэртэй сэргэлт	Суурь ба Хув.1-ийн ялгаа, %	Хув.2- "Урвуу-У" хэлбэртэй сэргэлт	Суурь ба Хув.2-ийн ялгаа, %
2020	76.93	76.93	-	76.93	-
2021	72.96	81.99	9.03	72.96	0
2022	69.18	77.43	8.25	79.13	9.95

Дүгнэлт



- 2020 онд бодит ДНБ 5.3%-иар буурсан нь уул уурхайн салбар 9.4%-иар буурсантай холбоотой
 - Хятадын эрэлтийн хэлбэлзэл
 - ГШХО-ын урсгал буурсан
 - Дэлхийн үнийн шок
 - Үйлдвэрлэл, тээврийн тасалдал
 - КОВИД-19-тэй холбоотой хөдөлмөрийн хязгаарлалт
- ЗГ-ын арга хэмжээний улмаас олон компани тогтвортой үйл ажиллагаагаа явуулж чадаагүй
 - Ихэнх компаниуд үйлдвэрлэл, борлуулалт, санхүүгийн бэрхшээлтэй тулгарсан
 - Томоохон хэсэг нь хөрөнгө оруулалт, хөдөлмөртэй холбоотой бэрхшээлүүдийг мөн дурдсан
 - КОВИД-19 улмаас нүүрс, төмрийн хүдрийн компаниуд тээвэрлэлтийн бэрхшээлтэй тулгарсан, зэсийн компаниудын ГШХО буурсан, алтны компаниуд харьцангуй бага өртөгдөн
- Гэсэн хэдий ч компаниуд ирээдүйн үйлдвэрлэл, борлуулалтыг өөдрөгөөр төсөөлж байв
- Компаниуд ЗГ-ын арга хэмжээг дагаж мөрдөхөд хүндрэлтэй хэмээн мэдэгдсэн

Загварын дүгнэлт

- Уул уурхайн салбарын өсөлт нь КОВИД-19-ийн дараах эдийн засгийг сэргээхэд чухал үүрэг гүйцэтгэнэ
 - Салбарын сэргэлт нь эдийн засаг хэвийн хэмжээнд хүртэл хэрхэн сэргэхийг тодорхойлно
- Ойрын хугацаанд эдийн засгийн тодорхойгүй байдал үргэлжилсээр байна
 - Дотоодын КОВИД-19 дэгдэлтээс хамааран хил хаах эрсдэлтэй

Анхаарал тавьсанд баярлалаа